Улсын нөөцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд олон нийтийн санал хэлэлцүүлэг хийсэн тухай танилцуулга

Хуулийн төслийг Хууль тогтоомийн тухай хуулийн 4.1.2-т заасны дагуу олон нийтийн оролцоог хангах, 38 дугаар зүйлийн 38.6-д заасны дагуу олон нийтийн хэлэлцүүлгийг 2026 оны 6 дугаар сарын 29-ны өдрөөс 7 дугаар сарын 09-ний өдрийн хооронд Монгол Улсын 21 аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар болон орон нутаг дахь төрийн захиргааны байгууллагууд болон Онцгой байдлын байгууллагын 3000 гаруй төлөөлөл оролцсон олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулав. Улсын нөөцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ирүүлсэн санал, тайлбарыг төсөлд тусгасан эсэх байдлаар нь нэгтгэн дараах байдлаар хураангуйлав.

1. Төсөлд тусгагдсан болон уялдуулан өөрчилсөн санал

Баянхонгор аймаг: Гамшгийн мэдээллийн санд өөрчлөлт орсон тухай бүрт бүртгүүлэх хугацааг “ажлын 3 өдөр” байсныг алслагдсан сумдын бодит нөхцөлийг харгалзан “ажлын 5 өдөр” болгон сунгаж өөрчилсөн.

Булган аймаг: Нөөцийн бараа материалыг хүргэхэд хоёрдмол утга үүсэхээс сэргийлж, 171.1.2 дахь заалтад “зориулалтын цэгт” гэснийг “заасан байршил, хугацаанд” гэж илүү тодорхой болгон тусгасан.

Завхан аймаг: Улсын нөөцийн агуулах, барилга байгууламжийн ашиглагдаагүй сул талбайг бусад бараа материал хадгалахад түрээслүүлэх зохицуулалтыг нөөцийн бэлэн байдал, аюулгүй байдлыг хангах нөхцөлтэйгээр тусгасан.

Архангай аймаг: Стратегийн болон гамшгийн нөөцийн бараа материалын санал боловсруулахтай холбоотой зарим саналууд төсөлд аль хэдийн тусгагдсан гэж үзсэн.

2. Төсөлд шууд тусгах боломжгүй, хууль тогтоомжийн зөрчилтэй болон бусад хуулиар зохицуулагддаг гэж үзсэн саналууд

Дараах аймгуудын ирүүлсэн зарим саналыг хууль зүйн техник, төсвийн болон бусад салбарын хуультай зөрчилдөх үндэслэлээр төсөлд шууд тусгах боломжгүй гэж үзсэн байна:

Төсөв, санхүүгийн зохицуулалтын хүрээнд (Баянхонгор, Говь-Алтай, Дархан-Уул, Дундговь, Ховд):



Зарцуулагдаагүй үлдсэн төсвийг дараа оны төсөвт шууд шилжүүлэх, Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас улсын нөөцийн зардлыг санхүүжүүлэх (Төсвийн тухай хуулийн зарчимтай зөрчилдөнө).

Нөөцийн барааг нөхөн бүрдүүлэх хугацааг хуулиар хатуу тогтоох, цагдаа, эрүүл мэнд, мал эмнэлгийн илүү цаг, шатахууны зардлыг нөөцийн тусгай санд хуримтлуулах.

Бусад салбарын хуулиар аль хэдийн зохицуулагдсан асуудлууд (Булган, Дархан-Уул, Дундговь, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ, Хөвсгөл):

Гамшгийн үед тендер шалгаруулалтгүйгээр шууд худалдан авалт хийх, чанаргүй барааг устгах, актлах, хандив тусламжийг бүртгэх харилцааг *Төрийн болон*

орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, *Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль*, *Гамшгаас хамгаалах тухай хуулиар* тус тус зохицуулдаг тул давхардуулахгүй.

Объектын хамгаалалт, аюулгүй байдлын норм стандарт, сургалт зохион байгуулах зэрэг нь байгууллагын дотоод журам болон холбогдох бусад хуулиар шийдвэрлэгдэнэ.



Бүтэц зохион байгуулалт, шийдвэр гаргах эрх мэдлийн хүрээнд (Баянхонгор, Өвөрхангай, Завхан):

Онцгой байдлын удирдах албан тушаалтан дур мэдэн шууд шийдвэр гаргаж улсын нөөц хөдөлгөх нь Засгийн газрын бүрэн эрхэд халдсан зөрчил болох тул хүлээн аваагүй.

Суман дахь төрийн орон тоог хуулиар тогтоох боломжгүй бөгөөд шинээр ажилтан нэмэхээс илүүтэйгээр төсөлд шинээр орж буй "Гэрээт хадгалагч" (хувийн хэвшлийн оролцоо)-ийн зохицуулалтаар шийдвэрлэх боломжтой гэж үзсэн.

3. Хуулийн төслийг дэмжсэн санал

Олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулсан Баян-Өлгий, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Увс, Хэнтий аймгаас Улсын нөөцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг бүхэлд нь дэмжиж, тусгайлан өгөх саналгүй тухай албан бичгээр баталгаажуулан ирүүлсэн.

---o0o---

УЛСЫН НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН САНАЛЫН ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ИРҮҮЛСЭН САНАЛЫН НЭГТГЭЛ

2026.10.13

д/д	Хуулийн төслийн саналын холбогдох заалт	Ирүүлсэн санал, саналын тайлбар	Саналыг судалж төсөлд тусгасан эсэх
1. Архангай аймаг (2026.07.07-ны 28/193)			
1	**15 дугаар зүйлийн 15.1.6 дахь заалт:** 15.1.6.улсын нөөцөд бүрдүүлэх стратегийн болон гамшгийн нөөцийн бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээ, байршлын талаарх саналыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулах.	15 дугаар зүйлийн 15.1.6-д шинээр нэмэх. 15.1.6.улсын нөөцөд бүрдүүлэх стратегийн болон гамшгийн нөөцийн бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээ, байршлын талаарх саналыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулах; -	Төсөлд тусгагдсан зүйлийг санал болгон ирүүлсэн.
2. Баянхонгор аймаг (2026.07.09-ны 29/182)			
2	**13 дугаар зүйлийн 13.1.11 дэх заалт:** "13.1.11.орон нутгийн нөөц бүрдүүлэх, хадгалах, зарцуулах журмыг батлах."	Орон нутгийн нөөцөд хадгалагдаж буй өвс тэжээлийн чанар байдалд орон нутгийн шинжээч, улсын байцаагчдын шалгалт үзлэгийг жилд 2 удаа зохион байгуулж стандарт хангаагүйг нь аймаг сумын онцгой комиссын шийдвэрээр тухай бүр устгах.	Уг саналыг Улсын нөөцийн тухай хуулийн төсөлд шууд тусгах шаардлагагүй бөгөөд хууль зүйн техник, хэм хэмжээний хувьд оновчгүй юм. Хуулийн төслийн үзэл баримтлалаар орон нутгийн нөөцийг зөвхөн "өвс, тэжээл"-ээр хязгаарлахгүй байхаар хэрэгцээ, шаардлагаа тодорхойлсон. Хэрэв хуульд зөвхөн өвс тэжээлийг онцлон заавал бусад нөөцийн барааны чанар, устгалын асуудал хуулийн гадна үлдэж, эрх зүйн хийдэл үүснэ. Тиймээс хуульд "нөөцийн бараа, материал" гэж нийтлэгээр томьёолсон. Чанар нь муудсан өмчийг устгах харилцаа нь "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль", "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль"-иар комисс гарч актлах г.м. байдлаар зохицуулагддаг. Үүнийг зөвхөн *"Онцгой комиссын шийдвэрээр тухай бүр устгана"* гэж заах нь

			өмчийн болон санхүүгийн хууль тогтоомжуудтай зөрчилдөж болзошгүй. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6-р зүйлийн 6.1.7-д “Гамшгийн мэдээллийн сан бүрдүүлэх”-ээр заасны дагуу Онцгой байдлын байгууллагад ашиглагдаж байгаа гамшгийн мэдээллийн сан, програм хангамжийн тусламжтайгаар нөөцийн бараа, материалын нэгдсэн тоо бүртгэлийг улсын хэмжээнд хөтлөх, уг бүртгэлд үндэслэн нөөцийн бараа, материалын удирдлага менежментийг хэрэгжүүлнэ. Орон нутгийн нөөцөд хадгалагдаж буй өвс тэжээлийн чанар байдалд үзлэг шалгалт зохион байгуулж, шаардлага хангаагүйг аймаг, сумын онцгой комиссын шийдвэрээр устгах асуудлыг журмаар зохицуулах боломжтой.
3		АОК-ын шийдвэрээр худалдан авах ажиллагааг хийдэг байх -	Шаардлагагүй. 1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, материал бэлтгэх харилцаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-иар зохицуулдана. Улсын нөөцийн тухай хуульд худалдан авах ажиллагааны онцгой эрхийг АОК шууд шийднэ гэж оруулах нь хууль хоорондын зөрчил үүсгэнэ. 2. Улс орны хэмжээний стратегийн болон гамшгийн нөөцийн мэдээлэл нь үндэсний аюулгүй байдалтай шууд холбоотой тул Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолын дагуу төрийн нууцад хамаарна. Аймаг, сум, дүүргийн төсвөөр бүрдүүлж буй нөөц нь Төрийн нууцын жагсаалтад шууд хамаарахгүй. Төсвийн тухай хуулийн 6.1, 60.3, Шилэн дансны тухай хуулийн 3.1, 6, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4.1, 8, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.1, Нийтийн сонсголын тухай хуулийн 10, 12-р зүйлүүдэд зааснаар орон нутгийн төсвийн зарцуулалт, иргэдийн хяналт болон шийдвэр гаргах үйл ажиллагаа нээлттэй байх зарчимтай. Гэвч орон нутгийн нөөц нь гамшгаас хамгаалах тогтолцооны нэг бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд түүний

			нэгдсэн мэдээлэл, хадгалалтын байршил зэрэг нь “Албаны нууц” болон шинээр боловсруулах “Гамшгийн мэдээллийн санд хандах эрх, нууцлалын журам”-аар хамгаалагдана.
4	**16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалт:** “16.1.1.орон нутгийн нөөцийг тухайн шатны Гамшгийн эрсдэлийг бууруулах санд жил бүр тодорхой хувийг тусгах замаар бүрдүүлэх, хадгалах, сэлгэх, шинэчлэх, зарцуулах ажлыг зохион байгуулах;	1. Орон нутгийн нөөцийг бүрдүүлэхэд тулгарах төсвийн дарамтыг зохицуулах. Хуулийн төслийн 16.1.1-д Орон нутгийн нөөц бүрдүүлэх тухай журмыг 13.1.11 батлахдаа тухайн засаг захиргааны нэгжийн гамшгийн эрсдэлийн индекс болон хүн амын тооноос хамааруулан **“нөөцөд байх ёстой бараа, материалын доод хэмжээ”** зааж өгөх. Шаардлагатай бол улсын төсвөөс эрсдэл өндөртэй орон нутагт санхүүгийн дэмжлэг (татаас) олгох заалтыг журамд тусгах Сум, дүүргүүдийн төсвийн орлого, Гамшгийн эрсдэлийг бууруулах сангийн чадавх харилцан адилгүй байдаг. Төсөв муутай алслагдсан сумдад “тодорхой хувиар” нөөц бүрдүүлэх нь практик дээр хангалтгүй хэмжээний бараа, материал хуримтлуулахад хүргэж болзошгүй. Шаардлагатай бол улсын төсвөөс эрсдэл өндөртэй орон нутагт санхүүгийн дэмжлэг (татаас) олгох заалтыг журамд тусгах шаардлагатай.	Төсөлд шууд тусгах шаардлагагүй. Хүн амын тоо, эрсдэлийн индексээс хамаарсан “тооцооллын аргачлал” болон барааны “доод хэмжээ”-г журмаар тогтоох боломжтой. Улсын төсвөөс орон нутагт “санхүүгийн дэмжлэг, татаас” олгох харилцаа нь Улсын нөөцийн тухай хуулиар бус, Төсвийн тухай хуулийн зохицуулалтаар (Орон нутгийн төсвийн суурь орлогын дутагдлыг санхүүжүүлэх хэсгээр) хийгддэг тул хууль хоорондын зөрчил үүсгэхгүй байх шаардлагатай. Хууль зүй, дотоод хэргийн сайдын ирүүлсэн саналын дагуу саналын 2, 3, 5, 6 дахь хэсэгтэй нийцүүлж, 16.1.1-д “тухайн шатны орон нутгийн төсөвт гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд аж ахуйн нэгж, байгууллагын нөөцөөс бусад орон нутгийн нөөц бүрдүүлэх, хадгалах, сэлгэх, шинэчлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр тусгах замаар бүрдүүлэлт, зарцуулалтын ажлыг зохион байгуулах” гэж өөрчлөн найруулсан.
5	**16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалт:** “16.1.4.энэ хуулийн 3.1.10-т заасан бараа, материалыг гамшгийн үед зарцуулсан тохиолдолд борлуулалтын орлого болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр нөхөн бүрдүүлэх.”	2. Зарцуулсан нөөцийг нөхөн бүрдүүлэх хугацааг тодорхой болгох. “...нөхөн бүрдүүлэх” гэсний дараа “...бөгөөд гамшгийн нөхцөл байдал арилснаас хойш ажлын 30-аас 60 хоногийн дотор (эсхүл тухайн жилийн төсвийн тодотголоор) нөхөн бүрдүүлнэ” гэсэн хугацааны хязгаарлалтыг журам эсвэл дагалдах заалтад маш тодорхой оруулах.	Төсөлд шууд тусгах шаардлагагүй. Төсвийн хөрөнгөөр нөхөн бүрдүүлэх хугацааг хуульд “30-60 хоног” гэж хатуу заах нь төсвийн орлогын тасалдал, улирлын чанартай бараа нийлүүлэлтийн хомсдол, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хугацаатай зөрчилдөх эрсдэлтэй. Төсвийн тодотгол хийх үйл явц нь УИХ эсвэл ИТХ-ын бүрэн эрхийн асуудал тул хугацааг зохицуулах боломжгүй юм.

		Гамшгийн үед зарцуулсан бараа, материалыг “Ямар хугацааны дотор” нөхөн бүрдүүлэхийг хуулийн төсөлд тодорхой заагаагүй байна. Энэ нь дараагийн гамшиг, эрсдэл нүүрлэхэд орон нутгийн нөөц хоосон байх эрсдэлийг үүсгэнэ.	Сангийн сайдын 2026.07.03-ны өдрийн 1/8199 тоот албан бичгээр ирүүлсэн саналын 6 дахь хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2026.06.29-ны өдрийн 1/3543 тоот албан бичгээр ирүүлсэн саналтай нийцүүлж, 16.1.4-д “аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн хөрөнгөөр бүрдүүлсэн орон нутгийн нөөцийн бараа, материалыг гамшгийн үед энэ хуулийн 9.1.1-д заасан нөхцөлөөр олсон орлого болон орон нутгийн тухайн жилийн батлагдсан төсвийн хөрөнгөөр нөхөн бүрдүүлэх” гэж өөрчлөн найруулсан.
6	**16 дугаар зүйлийн 16.1.3 дахь заалт:** 16.1.3.орон нутгийн нөөцийн мэдээллийг улирал тутам шинэчилж, өөрчлөлт орсон тухай бүрт ажлын 3 өдрийн дотор гамшгийн мэдээллийн санд бүртгүүлэх, хяналт тавих;	3. Мэдээллийн санд бүртгүүлэх хугацааны бодит боломж (Ажлын 3 өдөр) Өөрчлөлт орсон тухай бүрт ажлын 3 өдөр гэдгийг **“ажлын 3-5 өдрийн дотор” болгон сунгаж, орон нутгийн түвшний бодит нөхцөл байдалд нийцүүлэх.** Гамшгийн үед зарцуулсан бараа, материалыг “Ямар хугацааны дотор” нөхөн бүрдүүлэхийг хуулийн төсөлд тодорхой заагаагүй байна. Энэ нь дараагийн гамшиг, эрсдэл нүүрлэхэд орон нутгийн нөөц хоосон байх эрсдэлийг үүсгэнэ.	Төсөлд тусгасан. Орон нутгийн ялангуяа алслагдсан сум, багийн мэдээлэл холбоо, интернэтийн сүлжээ, дэд бүтцийн сул тал зэрэг бодит нөхцөл байдлыг тооцсон практик санал гэж үзэв. Хуулийн хэрэгжих боломжийг хангах үүднээс төслийн 16.1.5 дахь заалтын “ажлын 3 өдрийн дотор” гэснийг “ажлын 5 өдрийн дотор” гэж өөрчилж, хууль тогтоомжийн нийтийн ашиг сонирхолд нийцэх зарчимд нийцүүллээ.
7	**10 дугаар зүйлийн 10.2. дахь хэсэг:** 10.2.Агуулахын барилга байгууламж шинээр барих, өргөтгөх, агуулахын болон техникийн засвар үйлчилгээг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхдээ өмчлөх эрхийг төрд үлдээх нөхцөлтэйгөөр гүйцэтгүүлж болох бөгөөд түншлэгч нь Төрийн болон албаны нууцын тухай хуулиар тогтоосон	4. Орон нутгийн түвшинд төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих. Орон нутгийн нөөцийн агуулахыг (3.1.10) төр, хувийн хэвшлийн түншлэлээр орон нутагт барьж байгуулахыг урамшуулах үүднээс “Орон нутгийн нөөцийг хувийн хэвшлийн гэрээт хадгалагчийн агуулахад хадгалуулж болох” уян хатан зохицуулалтыг (17^1 дүгээр зүйлтэй уялдуулан) орон нутгийн түвшинд илүү нээлттэй болгох. Энэхүү заалт нь голчлон “Улсын нөөцийн агуулах”-д зориулагдсан мэт боловч орон	Сангийн сайдын 2026.07.03-ны өдрийн 1/8199 тоот албан бичгээр ирүүлсэн саналын 6 дахь хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2026.06.29-ны өдрийн 1/3543 тоот албан бичгээр ирүүлсэн саналтай нийцүүлж, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасны дагуу хэрэгжүүлэхээр тусгасан тул тусгагдсан санал гэж үзэв. Мөн төслийн 17^1 дүгээр зүйлд “Гэрээт хадгалагч”-ийн үүргийг хуульчилж өгсөн нь зөвхөн улсын нөөцөөр хязгаарлагдахгүй бөгөөд орон нутгийн нөөцийг хувийн хэвшлийн агуулахад хадгалуулах эрх зүйн орчныг нээж өгсөн байгаа. Нарийвчилсан харилцааг дагалдан гарах журмаар шийдвэрлэх боломжтой.

	аюулгүй байдлын шалгуурыг хангасан байна.	нутагт (аймаг, суманд) нөөцийн агуулах барихад хувийн хэвшлийг татан оролцуулах хөшүүрэг дутагдалтай байна.	3.1.10.“орон нутгийн нөөц” гэж аймаг, нийслэл, сум, дүүрэг болон хуульд заасан тохиолдолд аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зарцуулахаар бүрдүүлсэн бараа, материалыг; 10.2.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан шаардлага хангасан төслийн хүрээнд улсын нөөцийн агуулахын барилга байгууламж шинээр барих, өргөтгөж болно.
3. Булган аймаг (2026.07.02-ны 31/230)			
8	Төслийн 14.2. Улсын нөөцийн мэдээллийг Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан гамшгийн мэдээллийн санд бүртгэх бөгөөд уг мэдээллийн ангилал, хандах эрх, нууцлал, аюулгүй байдлыг хангах журмыг холбогдох хуульд нийцүүлэн Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	1 дүгээр зүйл: 14.2-д заасан “Гамшгийн мэдээллийн санд” бүртгэх гэснийг “**нөөцийн мэдээллийн санд**” бүртгэх, аюулгүй байдлыг хангах гэсний урд “цахим” гэж нэмэх	Шаардлагагүй. Хуулийн төслийн үзэл баримтлалаар Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6-р зүйлийн 6.1.7-д “Гамшгийн мэдээллийн сан бүрдүүлэх”-ээр заасны дагуу Онцгой байдлын байгууллагад ашиглагдаж байгаа гамшгийн мэдээллийн сан, програм хангамжийн тусламжтайгаар нөөцийн бараа, материалын нэгдсэн тоо бүртгэлийг мэдээллийн ангилал, хандах эрх, төрийн болон албаны нууцлал, аюулгүй байдлыг хангасан дэд санд улсын хэмжээнд хөтлөх, уг бүртгэлд үндэслэн нөөцийн бараа, материалын удирдлага менежментийг хэрэгжүүлэхээр хэрэгцээ, шаардлагаа тодорхойлсон.
9	Төслийн 15.1.5.улсын нөөцийн мэдээллийг гамшгийн мэдээллийн санд бүртгэх, хөтлөх	15 дугаар зүйлийн 15.1.5 дахь заалтад “гамшгийн мэдээллийн санд бүртгэх” гэснийг “**нөөцийн мэдээллийн санд**” гэж өөрчлөх	
10	Төслийн 17^1.1.2. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрийг үндэслэн нөөцийн бараа, материалыг зориулалтын цэгт тээвэрлэн хүргэх	17^1.1.2-д заасан “**зориулалтын цэгт**” гэснийг “**заасан байршил, хугацаанд**” гэж өөрчлөх	Саналыг дэмжсэн. Гамшгийн үед тусламжийг цаг алдалгүй хүргэх нь амь нас, эд хөрөнгө аврах гол хүчин зүйл тул хугацааг тогтоох, “зориулалтын цэг” гэж ерөнхий томьёолох нь хууль зүйн хувьд хоёрдмол утга санаа илэрхийлж болзошгүй тул эрх бүхий байгууллагын заасан яг тухайн газарт (гамшгийн голомт г.м) хүргэх хариуцлагыг тодорхой болгох ач холбогдолтой санал гэж үзэв.

			17[1].1.2.энэ хуульд заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрийг үндэслэн, онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын өгсөн чиглэлийн дагуу нөөцийн бараа, материалыг заасан байршил, хугацаанд тээвэрлэн хүргэх;
11	14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалтын "бүрдүүлэх" гэсний дараа ", агуулахын барилга байгууламжийг түншлэлээр хэрэгжүүлэх төслийн" гэж	14.1.1 "**бүрдүүлэх**" гэсний араас **"агуулах, барилга байгууламжийн засвар, өргөтгөлийг олон улсын гэрээ, түншлэл, төсөл хөтөлбөрөөр хийлгэх санхүүжүүлэх**" гэж	Саналын гол агуулга төсөлд илүү оновчтой байдлаар тусгагдсан тул яг энэ үг хэллэгээр тусгах шаардлагагүй. Төслийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан шаардлага хангасан төслийн хүрээнд улсын нөөцийн агуулахын барилга байгууламж шинээр барих, өргөтгөж болно." гэж маш тодорхой заасан. Олон улсын гэрээ болон төсөл, хөтөлбөрөөр санхүүжүүлэх асуудал нь Засгийн газрын нийтлэг бүрэн эрх бөгөөд Олон улсын гэрээний тухай хууль, Төсвийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хуулиар зохицуулагдах асуудлыг дахин тоочиж бичих нь эрх зүйн хийдэл, давхардал үүсгэнэ. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлээр "Олон улсын гэрээ"-г Улсын нөөцийн тухай хууль тогтоомжийн бүрдэл хэсэг байхаар нэмж тусгасан. Санхүүжилтийн эх үүсвэрийг 10 дугаар зүйлээр зохицуулдаг тул 14.1.1 буюу Засгийн газрын чиг үүргийг тодорхойлсон заалтад санхүүжилтийн хэлбэрийг хольж бичих нь хууль зүйн техникийн хувьд буруу гэж үзлээ. Төслийн 10.2 болон 14.1.1 дэх өөрчлөлтөөр, түүнчлэн бусад холбогдох хуулиудаар бүрэн шийдвэрлэгдсэн тул нэмж өөрчлөх шаардлагагүй.
4. Говь-Алтай аймаг (2026.07.03-ны 32/233)			
12	**16 дугаар зүйлийн 16.1.1:** 16.1.1.орон нутгийн нөөцийг тухайн шатны Гамшгийн эрсдэлийг бууруулах санд жил бүр тодорхой хувийг тусгах замаар бүрдүүлэх, хадгалах, сэлгэх, шинэчлэх,	16.1.1. хэсгийн шинээр нэмэх санал: орон нутгийн нөөцийг тухайн шатны Гамшгийн эрсдэлийг бууруулах санд жил бүр тодорхой хувийг тусгах замаар бүрдүүлэх, хадгалах, сэлгэх, шинэчлэх, зарцуулах ажлыг зохион байгуулах. Улсын нөөцийн сэлгэх, хадгалах зардлыг Гамшгийн	Саналыг хуулийн төсөлд шууд тусгах шаардлагагүй. Хууль зүйн хувьд зөрчилтэй бөгөөд гол агуулга төсөлд илүү оновчтой байдлаар тусгагдсан. Хувь зааж өгөх нь Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон УИХ-ын төсөв батлах бүрэн эрхэд халдсан хэрэг болж, Төсвийн тухай хуулийн санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчимтай зөрчилдөнө.

	зарцуулах ажлыг зохион байгуулах;	эрсдэлийг бууруулах санд жил бүр тодорхой хувийг тусгах	“Гамшгийн эрсдэлийг бууруулах сан” нь Гамшгаас хамгаалах тухай хуулиар зохицуулагддаг, урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгаа хийх зэрэг өөрийн гэсэн тусгай зориулалттай сан юм. Харин Улсын нөөцийн зардал (хадгалах, сэлгэх) нь тусгай сангаас бус Улсын төсвөөс шууд санхүүжих ёстой суурь зардал юм. Үүнийг сангаас санхүүжүүлэхээр уях нь нөөцийн үйл ажиллагааг доголдуулах эрсдэлтэй. Сангийн сайдын 2026.07.03-ны өдрийн 1/8199 тоот албан бичгээр ирүүлсэн саналын 6 дахь хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2026.06.29-ны өдрийн 1/3543 тоот албан бичгээр ирүүлсэн саналаар төслийн 16 дугаар зүйлийн 16.1.1-д “тухайн шатны орон нутгийн төсөвт гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд аж ахуйн нэгж, байгууллагын нөөцөөс бусад орон нутгийн нөөц бүрдүүлэх, хадгалах, сэлгэх, шинэчлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр тусгах замаар бүрдүүлэлт, зарцуулалтын ажлыг зохион байгуулах” гэж оновчтой, уян хатан байдлаар тусгагдсан.
5. Дархан-Уул аймаг (2026.07.08-ны 34/241)			
13	Төслийн 16.1.1, 16.1.3 дахь заалт (16 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх)	16 дугаар зүйлд сумын Засаг даргын бүрэн эрхийг тусад нь нэмж тусгах, эсхүл “аймаг, нийслэлийн Засаг дарга” гэдгийн дараа “сумын Засаг дарга”-ыг нэмж, заалтын нэрийг “Аймаг, нийслэл, сумын Засаг даргын бүрэн эрх” гэж өргөтгөх Сумын түвшинд улсын нөөцийн салбар нэгж байдаггүй, тиймээс орон нутагт нөөц хариуцсан нэгж байгуулах, эсхүл орон нутагт нөөц хариуцсан ажилтантай болгох	Шууд тусгах шаардлагагүй. Бүх суманд төрийн байгууллагын орон тоо, бүтэц шинээр нэмэх боломжгүй бөгөөд төсвийн ачааллыг нэмэгдүүлнэ. Энэ асуудлыг төсөлд шинээр орж буй “Гэрээт хадгалагч”-ийн зохицуулалтаар буюу хувийн хэвшлийн агуулах, хүн хүчийг гэрээгээр ашиглах байдлаар шийдвэрлэх боломжтой.
14	Төслийн 16.1.1 дэх заалт; 1 дүгээр зүйлийн 7-р заалт (16.1.4 дэх заалт)	Орон нутгийн нөөцийн санхүүжилтийн эх үүсвэрийг (Гамшгийн эрсдэлийг бууруулах сангийн хувь, орон нутгийн төсөв, борлуулалтын орлого) аль нь ямар	Хуулийн төсөлд тусгагдсан.

		тохиолдолд хэрэглэгдэхийг тодорхой ялгаж, журамд нарийвчлан тусгах Сумын гамшгаас хамгаалах нөөцийг хаанаас ямар эх үүсвэрээс бүрдүүлэх талаар тодорхой шийдэл байдаггүй. Үүнийг хуулинд тодорхой болгон зааж өгөх	Төслийн 16.1.1 дэх заалтад “тухайн шатны орон нутгийн төсөвт ... шаардагдах хөрөнгийг жил бүр тусгах” гэж маш тодорхой зааж өгсөн тул нэмж өөрчлөх шаардлагагүй.
15	Төслийн 16.1.1 дэх заалт	16.1.1-д “жил бүр тодорхой хувийг тусгах” гэсний дараа “тухайн жилд зарцуулаагүй үлдэгдлийг дараа жилд шилжүүлэн зарцуулна” гэсэн өгүүлбэр нэмж, олон жилийн хуримтлалын механизм бүрдүүлэх Жил бүр байгалийн гамшиг, осол, мал амьтны гаралтай өвчний гаралт адилхан байдаггүй. Зарим жилд нь байгалийн аюулт үзэгдэл, гамшиг осол, мал амьтны гаралтай халдвар өвчиний гаралт ихэсэж төсвийн зарцуулалт харьцангуй ихэсдэг. Зарим жилүүдэд буурах, гарахгүй байх зэргээс шалтгаалж санхүүгийн зардал харьцангуй ижил биш байдаг. Иймээс гамшиг, осол, мал, амьтны гаралтай халдварт өвчний гаралт бага жил орон нутагт нөөц хөрөнгийн зарцуулаагүй үлдсэн төсвийг дараа жилд нь шилжүүлэн зарцуулдаг эрх зүйн системийг оруулж өгөх шаардлагатай байна	Төсөлд тусгах шаардлагагүй. Зарцуулаагүй үлдсэн төсвийг дараа жилд шилжүүлэх саналыг хүлээн авах боломжгүй. Төсвийн хөрөнгийг дараа жилд шууд шилжүүлэн зарцуулах нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.3-д заасан төсөв жил бүр батлагдах болон үлдэгдэл хөрөнгийг зохих санд төвлөрүүлэх зарчимтай шууд зөрчилдөнө.
16	10.1.6.агуулахын барилга байгууламж шинээр барих, өргөтгөх, агуулахын болон техникийн засвар үйлчилгээний зардал. 10.2.Агуулахын барилга байгууламж шинээр барих, өргөтгөх, агуулахын болон техникийн засвар үйлчилгээг төр, хувийн хэвшлийн	10.1.6-д гамшиг, халдварт өвчний үед цагдаа, эрүүл мэнд, мал эмнэлэг болон холбогдох албан хаагчдын тээвэр, шатахуун, хоолны болон илүү цагийн зардлыг тусгайлан нэрлэж оруулах, мөн эдгээрийг орон нутгийн нөөцийн тусгай санд төвлөрүүлж, хуримтлуулах эрх зүйн үндэслэлийг нэмэх Орон нутагт аливаа нэгэн гамшиг, осол, мал, амьтны гоц халдварт өвчин гарсан	Төсөлд тусгах шаардлагагүй. Илүү цагийн хөлс, тээвэр шатахууны зардлыг нөөцийн тусгай санд хуримтлуулах санал хуулийн зорилтод нийцэхгүй тул хүлээн авах боломжгүй. Улсын нөөцийн тухай хууль нь нөөцийн бараа, материалын харилцааг зохицуулдаг. Бэлэн мөнгөний сан бүрдүүлэх, цалин урамшуулал олгох асуудал нь Гамшгаас хамгаалах тухай хууль болон Төсвийн тухай хуулийн “Засаг даргын нөөц сан”-гийн зохицуулалтад хамаарна.

	түншлэлээр хэрэгжүүлэхдээ өмчлөх эрхийг төрд үлдээх нөхцөлтэйгөөр гүйцэтгүүлж болох бөгөөд түншлэгч нь Төрийн болон албаны нууцын тухай хуулиар тогтоосон аюулгүй байдлын шалгуурыг хангасан байна.	тохиолдолд цагдаа, эрүүл мэнд, мал эмнэлэг болон албан хаагчдын эргүүлд ажиллах тээврийн хэрэгслэл, шатахууны зардал, илүү цагаар ажилласан тохиолдолд илүү цагийн ажлын хөлс зэргийг орон нутгийн нөөцийн тусгай санд төвлөрүүлэх, хуримтлуулах шаардлагатай байна.	
17	(3.1.10 дахь заалт – орон нутгийн нөөцийн тодорхойлолт)	3.1.10-т орон нутгийн нөөцийг зориулалт, ангиллаар нь (жиш. хөдөлбөр, эдийн засгийн гэх мэт) ялган тодорхойлж, ангилал тус бүрийг төсөвт хэрхэн суулгахыг журамд нарийвчлан заах Орон нутгийн нөөцийг хөтөлбөр, эдийн засгийн ангилалтай болгож төсөвт суулгах. Ангилал зориулалтыг тодорхой болгох	Төсөлд тусгах шаардлагагүй. Улсын нөөцийн тухай хууль болон нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийн санал, дагалдан гарах журамд аль алинд шууд хамаарахгүй. Төсвийн зардлын эдийн засгийн ангилал, зориулалтыг хуулиар биш, Төсвийн тухай хуульд заасны дагуу Сангийн сайдын тушаалаар баталж, өөрчилдөг.
18	16.1.1, 16.1.3 дахь заалт	16.1.1, 16.1.3-т орон нутгийн нөөцийг хариуцах тусгай нэгж, албан тушаалтныг томилохыг үүрэгжүүлж, төрийн бусад байгууллагын албан хаагчдыг өвс тэжээл бэлтгэх ажилд байнга татан оролцуулахыг хязгаарлах зохицуулалт нэмэх Орон нутгийн нөөцийг тусгайлан хариуцсан нэгжтэй болмоор байна. Учир нь төрийн байгууллагын албан хаагчдын хавар намарт өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхэд татан оролцуулж, өвс ачих буулгах, хураах, түгээх зэрэг ажилд байнга татан оролцуулж байна. Үүнийг зогсоож албан ёсоор хариуцсан нэгжтэй болгох	Төсөлд тусгах шаардлагагүй. 1-р саналтай ижил бөгөөд энэ асуудлыг төсөлд шинээр орж буй “Гэрээт хадгалагч”-ийн зохицуулалтаар буюу хувийн хэвшлийн агуулах, хүн хүчийг гэрээгээр ашиглах байдлаар шийдвэрлэх боломжтой. Нөөц бүрдүүлэх, сэлгэх, ачих буулгах ажлыг төрийн албан хаагчдаар бус гэрээт компаниудаар гүйцэтгүүлэх боломжтой.
19	(10.1.6, 10.2 дахь хэсэг); 3.1.11 дэх заалт (агуулахын тодорхойлолт)	10.1.6, 10.2-т орон нутгийн өвс тэжээлийн нөөцийн агуулах, савны хүрэлцээг сайжруулах зардлыг тусгайлан оруулах, мөн тухайн жилд зарцуулаагүй үлдсэн өвс	Төсөлд тусгагдсан болон бусад хуулиар зохицуулагдана. Агуулахын хүрэлцээний асуудлыг Төр, хувийн хэвшлийн түншлэлээр шийдвэрлэхээр төслийн 10.2-т оруулсан. Харин ашиглаагүй өвс, тэжээлийн байгалийн хорогдлыг

		тэжээлд хэвийн хорогдол тооцох журмыг нэмж заах Орон нутагт өвс тэжээлийн нөөцийг хадгалах агуулах савны хүрэлцээ хангамж муу. Жил бүр сумын нөөцийн өвс тэжээл авдаг боловч тухайн жилд зарцуулахгүй үлдсэн өвс тэжээлд хорогдол тооцдог болгох	тооцох, актлах, устгах харилцаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох журмаар зохицуулагдах тул нөөцийн хуульд давхардуулах шаардлагагүй.
6. Дундговь аймаг (2026.07.07-ны 37/190)			
20	Төслийн 13.1.11.орон нутгийн нөөц бүрдүүлэх, хадгалах, зарцуулахтай холбогдсон нийтлэг журмыг батлах.	Орон нутгийн нөөцийн бараа, материалын нэр төрөл, доод хэмжээ, байршлыг тухайн нутаг дэвсгэрийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ, хүн амын тоо, төвөөс алслагдсан байдал, тээвэр ложистикийн нөхцөлтэй уялдуулан тогтоох аргачлалыг хууль, журамд тодорхой тусгах.	Төсөлд тусгах шаардлагагүй. “Орон нутгийн нөөц бүрдүүлэх, хадгалах, зарцуулах журам”-аар нарийвчлан батлах боломжтой. Хууль нь нийтлэг хэм хэмжээ тогтоодог. “Аргачлал, тооцоолол” нь цаг үе, эрсдэлийн нөхцөл байдлаас шалтгаалан өөрчлөгдөх магадлалтай тул Засгийн газар эсвэл сайдын батлах журмаар уян хатан зохицуулах нь хууль зүйн техникт нийцнэ.
21	***	Орон нутгийн нөөцийг орон нутгийн төсөв, Гамшгийн эрсдэлийг бууруулах сан, улсын төсвийн дэмжлэг болон хуульд нийцсэн бусад эх үүсвэрээс санхүүжүүлж болохоор зохицуулалтыг өргөжүүлэх.	Тусгах боломжгүй. Орон нутгийн нөөцийг давхардуулан санхүүжүүлэх нь Төсвийн тухай хуулийн орон нутгийн төсөв бие даасан байх зарчим, сангийн зориулалттай шууд зөрчилдөнө.
22	14.1.5.гамшгийн онцгой нөхцөл байдал, голомтын бүсэд нэн түрүүнд шаардлагатай нөөцийн бараа, материалыг улсын нөөцөөс гаргаж, Засгийн газарт танилцуулах	Нөөцийн бараа, материалыг шуурхай гаргах нөхцөл, шалгуур, шийдвэрлэх түвшин, зарцуулах дээд хэмжээ, тайлагнах болон нөхөн бүрдүүлэх хугацааг тодорхой тусгах.	Дагалдах журамд тусгана. Зарцуулалтын шалгуур, нөхөн бүрдүүлэх хугацаа зэрэг нь гамшгийн хэмжээ, төсвийн худалдан авах ажиллагаанаас шалтгаалах захиргааны үйл ажиллагаа тул хуульд хатуу заах боломжгүй.
23	14.2.Улсын нөөцийн мэдээллийг гамшгийн мэдээллийн санд бүртгэх, аюулгүй байдлыг хангахтай холбоотой журмыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн	Нэгдсэн мэдээллийн санг гамшгийн мэдээллийн сантай уялдуулж, аймаг, сумын түвшинд эрхийн ялгаатай хандалттай ашиглах, интернет сүлжээ	Тусгах шаардлагагүй. Мэдээллийн санг “оффлайн” ажиллуулах, “эрхийн ялгаатай хандалттай” байх зэрэг нь хуулиар тогтоох хэм хэмжээ биш, харин системийн хөгжүүлэлт, технологийн техникийн шаардлага юм.

	Засгийн газрын гишүүн батална.	тасарсан үед оффлайн горимоор ажиллах боломжтой байхаар зохицуулах.	Гэвч Сангийн сайдын 2026.07.03-ны өдрийн 1/8199 тоот албан бичгээр ирүүлсэн саналын 6 дахь хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2026.06.29-ны өдрийн 1/3543 тоот албан бичгээр ирүүлсэн саналаар хуулийн төслийн 14.2-т "мэдээллийн ангилал, хандах эрх, нууцлал, аюулгүй байдлыг хангах журам" батлахаар тусгасан.
24	7.5. Энэ хуулийн 7.4-т заасан түрээсийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлж, улсын нөөцийн барилга байгууламжийн засвар үйлчилгээний зардлыг тухайн жилийн төсөвт тусган санхүүжүүлнэ.	Түрээсийн орлогын тодорхой хувийг тухайн агуулахын засвар, тоног төхөөрөмжийн шинэчлэл, хадгалалтын нөхцөлийг сайжруулахад зориулалтын байдлаар зарцуулах зохицуулалтыг тусгах.	Тусгах боломжгүй. Төрийн болон орон нутгийн өмчийн түрээсээс олсон орлого шууд Төрийн сангийн нэгдсэн дансанд төвлөрөх ёстой. Тухайн байгууллага орлогоо өөрийн үйл ажиллагаанд шууд суутган зарцуулах нь Төсвийн тухай хуулийн зарчимтай зөрчилдөнө.
25	17^1 дугаар зүйл. Гэрээт хадгалагчийн үүрэг	Гэрээт хадгалагчийн даатгал, хохирол нөхөн төлөх нөхцөл, хадгалалтын алдагдлын хүлцэх хэмжээ, галын болон объектын аюулгүй байдлын шаардлага, гэрээ цуцлах үндэслэлийг нарийвчлан зохицуулах.	Шууд тусгах шаардлагагүй. Иргэний хуулийн гэрээний эрх зүйгээр зохицуулагдана. Гэрээ цуцлах, хохирол нөхөн төлөх, даатгалын асуудлыг Улсын нөөцийн тухай хуулиар давхардуулж зохицуулахгүй. Талуудын байгуулах "Гэрээ"-гээр нарийвчлан зохицуулна.
26	-	Нөөцийн бараа, материалыг хадгалалтын хугацаа дуусахаас өмнө сэлгэх хугацаа, FIFO/FEFO зарчим, чанарын хяналтын давтамж, шинжилгээний шаардлагыг холбогдох журамд тодорхой тусгах.	Тусгах шаардлагагүй. Санал гаргагч өөрөө саналдаа "холбогдох журамд тусгах" гэж тодорхойлсон байна. Энэ нь цэвэр агуулахын дотоод горимын заавар юм.
27	-	Гамшгийн үед зарцуулсан орон нутгийн нөөцийг нөхөн бүрдүүлэх хугацааг тодорхой тогтоож, ердийн нөхцөлд 30-90 хоногийн дотор, онцгой тохиолдолд нөхцөл байдалтай уялдуулан эрх бүхий байгууллагын шийдвэрээр хугацааг тогтоох.	Шууд тусгах шаардлагагүй. Хугацааг хуульд "30-90 хоног" гэж хатуу заах нь худалдан авах ажиллагааны хуулийн хугацаатай зөрчилдөх эрсдэлтэй.

28	-	Аймгийн төвөөс гадна гамшгийн эрсдэл, зам тээврийн нөхцөл, алслагдсан байдлыг харгалзан бүсчилсэн болон сум дундын нөөцийн цэг байгуулах эрх зүйн боломжийг журамд тусгах.	Шууд тусгах шаардлагагүй. Хуулийн төсөлд орон нутаг нөөцтэй байхыг аль хэдийн тусгасан. Харин тухайн нөөцийн цэгийг суманд, эсвэл сум дунд байрлуулах нь Засаг дарга болон гүйцэтгэх засаглалын хүрээнд шийдвэрлэх зохион байгуулалтын асуудал тул хуульд тусгах шаардлагагүй.
29	-	Аймаг, сумын нөөцөд жилд нэгээс доошгүй удаа хамтарсан үзлэг, тооллого хийж, чанар, хугацаа, хадгалалтын нөхцөл, бэлэн байдлыг үнэлэх нэгдсэн шалгуур үзүүлэлттэй болгох.	Шууд тусгах шаардлагагүй. Дотоод журам, хяналтын байгууллагын төлөвлөгөөгөөр зохицуулна. Тооллого хийх нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиар аль хэдийн үүрэгжүүлэгдсэн асуудал бөгөөд хамтарсан хяналт шалгалтыг дотоод журмаар зохицуулах бүрэн боломжтой.
7. Завхан аймаг (2026.07.06-ны 38/132)			
30	-	Улсын нөөцийн салбар, цэгтэй сумдад хариуцсан нэг албан тушаалтныг томилох.	Тусгах шаардлагагүй. Байгууллагын дотоод бүтэц, орон тооны баримт бичгээр зохицуулагдана. Төрийн цэргийн болон тусгай чиг үүргийн байгууллагын суман дахь орон тоо, бүтцийг хуулиар хатуу зааж тогтоодоггүй. Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар батлагддаг захиргааны зохион байгуулалтын асуудал юм. Түүнчлэн хуулийн төсөлд орж буй “Гэрээт хадгалагч” зохицуулалтаар заавал төрийн албан хаагч томилохгүйгээр хувийн хэвшлээр хариуцуулан гүйцэтгүүлэх бүрэн боломжтой.
31	7.4. Улсын нөөцийн агуулах, барилга байгууламжийн ашиглагдаагүй байгаа багтаамжийг стандартын шаардлага хангасан бусад бараа, материалыг хадгалахад гэрээний үндсэн дээр түрээслүүлж болно.	7.4. Улсын нөөцийн агуулах, барилга байгууламжийн ашиглагдаагүй байгаа багтаамжийг стандартын шаардлага хангасан бусад бараа, материалыг хадгалахад Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 26.1-д заасан шалгалтад хамрагдсан хуулийн этгээдэд гэрээний үндсэн дээр түрээслүүлж болно.	Тусгасан. Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Хууль зүй, дотоод хэргийн сайдаас ирүүлсэн саналын 8 дахь хэсэгтэй утга давхцаж байна. Улсын нөөцийн агуулах, барилга байгууламжийн ашиглагдаагүй байгаа багтаамжийг гэрээний үндсэн дээр улсын нөөцийн бэлэн байдал, технологийн горим, аюулгүй

			байдлыг алдагдуулахгүйгээр, гамшгийн үед шууд чөлөөлөх нөхцөлтэйгөөр Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлэхээр тусгаж, 7.5, 7.6 дахь хэсгийг “7.5.Улсын нөөцийн агуулах, барилга байгууламжийн ашиглагдаагүй байгаа багтаамжийг улсын нөөцийн бэлэн байдал, технологийн горим, аюулгүй байдлыг алдагдуулахгүйгээр, гамшгийн үед шууд чөлөөлөх нөхцөлтэйгөөр Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомжид нийцүүлэн гэрээний үндсэн дээр түрээслүүлж болно. 7.6.Энэ хуулийн 7.5-д заасан түрээсийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлнэ.” гэж өөрчлөв.
32	-	Улсын нөөцийн тухай хуульд Улсын нөөцийг суманд бүрдүүлбэл иргэдэд хүрэх хуртээмж нь сайжрах, малчдад цаг алдалгүй хүргэх, шатахууны зардал бага гарах боломжтой гэж үзэж байна.	Тусгагдсан санал зүйл заалт нэмэх шаардлагагүй. Хуулийн төслийн Үзэл баримтлалд тусгасан гол үндэслэл нь аймаг, сумын түвшинд “Орон нутгийн нөөц” бүрдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн явдал юм. Улсын нөөцийг 330 суманд байршуулах нь төсөв болон удирдлагын хувьд боломжгүй бөгөөд үүний оронд сумын Засаг дарга өөрийн төсвөөр орон нутгийн нөөцөө бүрдүүлж, гамшгийн үед малчид, иргэдэд цаг алдалгүй шуурхай хүргэх боломжийг хуулийн төслийн орон нутгийн нөөц гэсэн зүйл заалтаар шийдвэрлэж саналын зорилго биелсэн гэж үзнэ.
8. Орхон аймаг (2026.07.08-ны 39/183)			
33	Төслийн 3.1.8. .“улсын нөөцийн анги, салбар” гэж Засгийн газраас тогтоосон байршил, нэр төрөл, тоо хэмжээний дагуу нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, тэдгээрийн хадгалалт, сэлгэлт, шинэчлэлт болон багцлалт, тээвэр, хангамжийн зохион байгуулалт, зарцуулалтыг	3.1.8. “Улсын нөөцийн салбар” гэснийг Анги болгон өөрчлөх	Төсөлд тусгагдсан асуудал Төслийн 3 дугаар зүйлийн 1-д хуулийн 3.1.8 дахь заалтыг “... “Улсын нөөцийн анги, салбар” гэж...” тодорхойлохоор өөрчлөн найруулсан. Салбарыг анги болгох бүтцийн өөрчлөлтийг хэлж байгаа бол Засгийн газрын тогтоолоор ОБЕГ-ын бүтцийг батлахдаа шийдвэрлэх бүрэн боломжтой.


	хариуцан гүйцэтгэгч Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын харьяа нэгжийг		
34		- Барааг хадгалах бол бүс нутгийн хэмжээнд стратегийн бараа бүтээгдэхүүний тоо ширхэгийг дэлгэрэнгүй заах. - Бараа материал сэлгэхтэй холбоотой зардал, алба хаагчдын хувцас хэрэглэлийн норм, халаалттай болон хүйтэн агуулахад ажиллах цагийн норм, олгогдох хор саармагжуулах бүтээгдэхүүн, стандарт зэргийг тодорхой болгож өгөх.	Тусгах боломжгүй. - Нөөцлөх барааны "тоо ширхэг, хэмжээ" нь хүн амын өсөлт, эдийн засгийн байдал, гамшгийн эрсдэл зэргээс шалтгаалан байнга өөрчлөгдөж байдаг тул хуульд хатуу тоогоор заах нь тохиромжгүй. Засгийн газрын "Улсын нөөцийн бараа, материалын жагсаалт, тоо хэмжээ" батлах тогтоолоор зохицуулагдана. - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон ОБЕГ-ын даргын батлах дотоод журам, заавар, үндэсний стандартаар зохицуулна. Энэ нь хуулиар зохицуулах нийтлэг хэм хэмжээ биш бөгөөд цэвэр байгууллагын дотоод үйл ажиллагаа, хөдөлмөр хамгааллын нарийвчилсан заавар, стандартын асуудал юм. Түүнчлэн нөөц сэлгэх зардлыг хуулийн дагуу тухайн жилийн төсөвт тусгаж шийдвэрлэдэг тул Улсын нөөцийн тухай хуульд нарийвчлан норматив тогтоох нь хууль хоорондын давхардал, зөрчил үүсгэнэ.
9. Өвөрхангай аймаг (2026.07.07-ны 40/169)			
35		Улсын нөөцийн тухай хуулийн нөөцийн чанар, эргэлтийн тогтолцоог сайжруулах, хугацаа дуусахаас өмнө эргэлтэд оруулж, шинэ бараагаар нөхөн бүрдүүлэх (зарчим)-ийг хуульчлах;	Шаардлагагүй. Бараа материалыг хадгалалтын хугацаа дуусахаас өмнө сэлгэх, эргэлтэд оруулах, нөхөн бүрдүүлэх асуудал нь Улсын нөөцийн тухай хуулийн салшгүй үндсэн зарчим бөгөөд одоогийн хууль болон шинэ төсөлд бүрэн хуульчлагдсан.
36		Ил тод, хариуцлагатай худалдан авалт, Нөөц бүрдүүлэх худалдан авалтыг цахим, нээлттэй, аудитын хяналттай явуулах зохицуулалт тусгах, Нөөцийг зориулалтын бусаар ашиглах, үрэгдүүлэх, чанарын	Тусгах шаардлагагүй. Цахим, нээлттэй худалдан авалт хийх харилцаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Шилэн дансны тухай хуулиар бүрэн зохицуулагддаг. Зориулалтын бусаар

		шаардлага хангахгүй бараа нийлүүлэхэд ногдуулах хариуцлагыг тодорхой болгох;	ашиглах, чанаргүй бараа нийлүүлэх үеийн хариуцлагыг Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хүлээлгэдэг тул Улсын нөөцийн хуульд давхардуулах шаардлагагүй.
37		Улсын нөөцийн бараа материалд жилд 2-оос доошгүй удаа мэргэжлийн байгууллагын дүгнэлт шаардлагатай хугацаанаас урьдчилж гаргах ажлын хугацааг тодорхой болгох, холбогдох байгууллагуудтай харилцан тохиролцож хуульчлах;	Тусгах шаардлагагүй. Салбарын дотоод журам, хяналтын байгууллагын төлөвлөгөөгөөр зохицуулагдана.
38		Онцгой байдлын байгууллага нь улсын нөөцтэй холбоотой сургалт, дадлага сургуулилтыг жил бүр зохион байгуулж, холбогдох байгууллагуудыг хамруулна;	Тусгах шаардлагагүй. Сургалт, дадлага зохион байгуулах нь Гамшгаас хамгаалах тухай хуулиар хүлээсэн ОБЕГ-ын өдөр тутмын үндсэн чиг үүрэг тул бараа, материал зохицуулдаг хуульд оруулах шаардлагагүй.
39		Улсын нөөцийн агуулах, салбаруудыг бүсчилсэн байдлаар байршуулах бөгөөд онцгой байдлын байгууллага нь тэдгээрийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт тавина;	Тусгах шаардлагагүй. Улсын нөөцийн салбар, цэгийн байршлыг гамшгийн эрсдэл, тээвэр логистикийн тооцоололд үндэслэн Засгийн газар тогтоодог. Үйл ажиллагаанд хяналт тавих нь холбогдох хуулиар аль хэдийн баталгаажсан.
40		1. Гамшгийн үед улсын нөөцийг ашиглах шийдвэрийг дараах журмаар гаргана: 1.1. Яаралтай нөхцөлд онцгой байдлын байгууллагын удирдах албан тушаалтан шууд шийдвэр гаргаж хэрэгжүүлэх; 1.2. шийдвэрийг 24 цагийн дотор холбогдох дээд шатны байгууллагад мэдэгдэж баталгаажуулах; 1.3. улсын нөөц ашигласан тайланг гамшиг дуусснаас хойш 14 хоногийн дотор гаргах;	Тусгах боломжгүй. Гамшгийн үед удирдах албан тушаалтан "шууд шийдвэр гаргах" саналыг хүлээн авах боломжгүй. Улсын нөөц нь үндэсний аюулгүй байдлын баталгаа бөгөөд түүнийг зарцуулах шийдвэрийг Засгийн газар гаргадаг. Онцгой байдлын удирдах албан тушаалтан дур мэдэн “шууд шийдвэр гаргаж” улсын хөрөнгийг хөдөлгөх нь Төсвийн тухай хууль болон Засгийн газрын бүрэн эрхэд халдсан ноцтой зөрчил болно. Харин хуулийн төслийн 14.1.5-д “Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан гамшгийн онцгой нөхцөл байдал,

41		2. Гамшгийн үед улсын нөөцийг ашиглах шийдвэрийг дараах журмаар гаргана: 2.1. яаралтай нөхцөлд онцгой байдлын байгууллагын удирдах албан тушаалтан шууд шийдвэр гаргаж хэрэгжүүлэх; 2.2. шийдвэрийг 24 цагийн дотор холбогдох дээд шатны байгууллагад мэдэгдэж баталгаажуулах; 2.3. улсын нөөц ашигласан тайланг гамшиг дууссанаас хойш 14 хоногийн дотор гаргах;	голомтын бүсэд шаардлагатай гамшгийн нөөцийн бараа, материалыг Засгийн газраас тогтоосон хязгаарт багтаан гаргах" бүрэн эрх Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд байхаар тусгасан. Тайлагнах хугацааны хувьд "Улсын нөөц бүрдүүлэх, зарцуулах журам"-д тусгагдаг захиргааны процесс юм.
42		3. Онцгой байдлын байгууллага нь улсын нөөцийн дараах бэлэн байдлыг хангана; 3.1. стратегийн нөөцийг байнгын бэлэн байдалд байлгах; 3.2. хадгалалт, тээвэрлэлт, хамгаалалтын стандартыг мөрдөх; 3.3. шаардлагатай үед 12-24 цагийн дотор улсын хэмжээнд дайчлах боломжийг бүрдүүлэх;	Тусгах шаардлагагүй. Стандарт мөрдөх нь Стандартчилал, техникийн зохицуулалтын тухай хуулиар бүх байгууллагад хуульчлагдсан үүрэг. Харин "12-24 цагийн дотор дайчлах" гэдэг нь хуулийн нийтлэг хэм хэмжээ биш бөгөөд Гамшгаас хамгаалах шуурхай төлөвлөгөөнд тусгагдаг тактикийн цаг хугацааны хэмжүүр юм.
10. Сэлэнгэ аймаг (2026.07.21-ны 31/260)			
43	-	Гамшигтай тэмцэх үйл ажиллагаанд зориулж ирүүлсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хандив, тусламжийг орон нутгийн нөөцөд бүртгэж авч болно. Гамшигтай тэмцэх үйл ажиллагаанд зориулж ирүүлсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хандив, тусламжийг зориулалтын бусаар ашиглахыг хориглоно.	Тусгах шаардлагагүй. Гамшгийн үеийн хандив, тусламжийг хүлээн авах, бүртгэх, зарцуулах харилцааг Гамшгаас хамгаалах тухай хууль болон Төсвийн тухай хуулиар зохицуулсан. Түүнчлэн аливаа нийтийн хөрөнгө, нөөцийг зориулалтын бусаар зарцуулахыг хориглох нь Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хүлээлгэх нийтлэг хариуцлага тул Улсын нөөцийн тухай хуульд дахин бичиж хуулийн давхардал үүсгэх шаардлагагүй.
11. Ховд аймаг (2026.07.06-ны 46/227)			

45	-	10.1.2. Нөөцийн бараа материалыг шинэчилж, сэлгэхэд гарсан үнийн зөрүүг нөхөн олгох.	Тусгах шаардлагагүй. Нөөц сэлгэх, шинэчлэхэд шаардагдах хөрөнгийг улсын төсөвт жил бүр тусгаж санхүүжүүлэх заалт хуулийн төсөлд аль хэдийн орсон. "Үнийн зөрүү" зэрэг зардлын нарийвчлал Төсвийн тухай хуулийн дагуу төсөв төлөвлөх процесс.
	7.4. Улсын нөөцийн агуулах, барилга байгууламжийн ашиглагдаагүй байгаа багтаамжийг стандартын шаардлага хангасан бусад бараа, материалыг хадгалахад гэрээний үндсэн дээр түрээслүүлж болно.	7.4. Улсын нөөцийн агуулах, барилга байгууламжийн ашиглагдаагүй байгаа багтаамжийг стандартын шаардлага хангасан бусад бараа, материалыг хадгалахад Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 26.1-д заасан шалгалтад хамрагдсан хуулийн этгээдэд гэрээний үндсэн дээр түрээслүүлж болно.	Тусгах боломжгүй. Төрийн өмчийн түрээсийн нийтлэг харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулдаг.
12. Хөвсгөл аймаг аймаг (2026.07.06-ны 47/193)			
46		Гамшгаас хамгаалах эрсдэл үүссэн үед холбогдох бараа материалыг тендер шалгаруулалтгүйгээр шууд худалдан авах талаар нэмэлт өөрчлөлт оруулах	Энэ асуудал нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн зохицуулалтаар аль хэдийн хуульчлагдсан байдаг. Тухайн хуульд "давагдашгүй хүчин зүйл, гамшиг үүссэн онцгой нөхцөл байдлын үед тендер зарлахгүйгээр шууд гэрээ байгуулах" уян хатан заалт хүчин төгөлдөр үйлчилж байгаа, мөн тул салбарын хуульд давхардуулах шаардлагагүй.
47	-	Улсын нөөцийн салбар, цэг нь улсын онц чухал объект тул харуул, хамгаалалт, аюулгүй байдлыг Дотоодын цэрэг хариуцах	Тусгах шаардлагагүй. Аль объектыг "Улсын онц чухал объект"-д тооцох, түүнийг дотоодын цэрэг эсвэл гэрээт харуулаар хамгаалуулах эсэхийг хуулиар биш, Дотоодын цэргийн тухай хууль болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжийг үндэслэн Засгийн газрын тогтоолоор жагсаалт гарган баталж шийдвэрлэдэг гүйцэтгэх засаглалын бүрэн эрхийн асуудал юм. Монгол улсын Засгийн газрын 2017 оны Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад авах улсын онц чухал обьектын

			жагсаалт батлах тухай 281 дүгээр тогтоолд Онцгой байдлын байгууллагын байршил тусгагдаагүй.
13. Баян-Өлгий аймаг (2026.07.09-ны 30/182)			
	Тусгайлан өгөх саналгүй дэмжиж байна.		
14. Говьсүмбэр аймаг (2026.07.06-ны 33/157)			
	Тусгайлан өгөх саналгүй дэмжиж байна.		
15. Дорноговь аймаг (2026.07.07-ны 36/183)			
	Тусгайлан өгөх саналгүй дэмжиж байна.		
16. Дорнод аймаг (2026.07.01-ны 35/272)			
	Улсын нөөцийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэхэд нэмэлтээр оруулах санал байхгүй бөгөөд төслийг бүхэлд нь дэмжсэн.		
17. Өмнөновь аймаг (2026.07.09-ны 41/301)			
	Улсын нөөцийн тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг дэмжиж байна.		
18. Сүхбаатар аймаг (2026.07.22-ны 43/206)			
	Улсын нөөцийн тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг дэмжиж байна.		
19. Төв аймаг (2026.07.06-ны 44/174)			
	Тусгайлан өгөх саналгүй дэмжиж байна.		
20. Увс аймаг (2026.07.08-ны 45/285)			
	Тусгайлан өгөх саналгүй дэмжиж байна.		
21. Хэнтий аймаг (2026.07.07-ны 48/219)			
	Тусгайлан өгөх саналгүй дэмжиж байна.		


legalinfo.mn
ЗД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ДАГАСАН (0)
УЗСЭН (281)
САНАЛ (0)
ЭДИЙН ЗАСГИЙН ТУСГАЙ БУСИЙН ТУХАЙ
ДАГАСАН (5)
УЗСЭН (596)
САНАЛ (4)
АВЛИГЫН ХӨРӨНГИЙГ ХУРААЖ, ХУУХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН САНД ТӨВЛӨРТҮҮЛЖ ЗАРЦУУЛАХ ТУХАЙ
ДАГАСАН (0)
УЗСЭН (1053)
САНАЛ (0)
УЛСЫН НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ДАГАСАН (0)
УЗСЭН (1408)
САНАЛ (35)
1/34
Нийт: 136

"ЭРСДЭЛГҮЙ АМЬДРАЛЫН ТӨЛӨӨ" ТББ

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Энхтайвны өргөн чөлөө, 5 дугаар хороо, Утас: 99092682
E-mail: rbatmend@gmail.com

2026.10.14 № 02/103

танай _____-ны №_____-т

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА, ХОШУУЧ ГЕНЕРАЛ Г.АРИУНБУЯН ТАНАА

Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй танилцлаа.

Хуулийн төсөлд тусгайлан хүргүүлэх саналгүй болно.

УЛААНБААТАР ХОТ
ЭРСДЭЛГҮЙ АМЬДРАЛЫН ТӨЛӨӨ ТББ
1118262129 8276366 ШТ72179

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Р.БАТМЭНД

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АХМАДЫН ХОРОО

202... оны .... сарын .... өдөр

№ 35

Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, 4-р хороо
Партизаны гудамж-6
Утас: 263575, 99821957

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Г.АРИУНБУЯН ТАНАА

Хуулийн төсөлд санал хүргүүлэх тухай

Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй танилцлаа.

Хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа бөгөөд тусгайлан хүргүүлэх саналгүй болно.

АХМАДЫН ХОРООНЫ УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА С.ЦОГТБААТАР